



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 87

Хэрлэн сум

Төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион
байгуулах салбар комисс томилох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, 33.2.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.6, 3.5, 3.5.3, 2023 оны “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам, загвар батлах тухай” 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 6.1, 6.5-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.2024 оны 4 дүгээр улирлын төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулах салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Салбар комиссын

дарга:

Ч.Баярцолмон

Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

С.Бат-Эрдэнэ

Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга

Г.Сэдэдмаа

Салбар зөвлөлийн гишүүн, Статистикийн хэлтсийн дарга

Д.Ганболд

Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн албаны ахмад ажилтан

Нарийн бичгийн

дарга:

Ж.Саруултөгс

Салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга

2.Салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллах туслах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Төрийн албаны ерөнхий шалгалтыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж, дүнг танилцуулахыг салбар комиссын бүрэлдэхүүнд даалгасугай.

4.Төрийн албаны ерөнхий шалгалтын тайланг хугацаанд нь Төв комисст хүргүүлэхийг Нарийн бичгийн дарга (Ж.Саруултөгс)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА